



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ**

2026 оны 04 сарын 17 өдөр

Дугаар 26/10

Улаанбаатар хот

**Малын тоо толгойд ногдуулах  
албан татварын хэмжээг тогтоох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.4, 35 дугаар зүйлийн 35.1.10 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийг үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит VII хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Дүүргийн нутаг дэвсгэрт мөрдөгдөх малын тоо толгойн албан татварын хэмжээг хавсралтаар баталсугай.

2. Малын тоо толгойд ногдуулах албан татварыг дүүргийн төсвийн орлогод төвлөрүүлж, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг дүүргийн Засаг дарга (А.Сүхболд)-д үүрэг болгосугай.

3. Уг тогтоолыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэн захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд өөрчлөлт оруулахыг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга (М.Давааням)-д даалгасугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлд даалгасугай.

5. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн А/01 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Ф.МӨНХГЭРЭЛ

**1226010032**

Багахангай дүүргийн Иргэдийн  
Төлөөлөгчдийн Хурлын 2006 оны 04 дүгээр  
сарын 17 -ны өдрийн 65/10 дугаар тогтоолын  
хавсралт

НЭГ. МАЛЫН НЭГ ТОО ТОЛГОЙД ТУХАЙН ТАТВАРЫН ЖИЛД НОГДУУЛАХ  
АЛБАН ТАТВАРЫН ХУВЬ ХЭМЖЭЭ

№	Малын төрөл	Татварын хувь хэмжээ
1	Тэмээ	1000
2	Адуу	1000
3	Үхэр	1000
4	Хонь	300
5	Ямаа	500

ХОЁР. ТАТВАРЫН ХУВЬ ХЭМЖЭЭ 0 БАЙХ МАЛЫН ТОО

№	Малын төрөл	Малын тоо
1	Тэмээ	1
2	Адуу	1
3	Үхэр	1
4	Хонь	10
5	Ямаа	10